



**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Захиргаа захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн нэг, 47 дугаар зүйлийн 2-ыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Албаны хаягдал утааны хийн TESTO-350 XL багажид үйлдвэрийн тохиргоо, засвар үйлчилгээ хийлгэх, орчны агаарын дахь тоос тоосонцор хэмжигч DUSTTRACK-8533 багажийг үйлдвэрийн тохиргоонд оруулах, орчны агаарын чанарыг хэмжигч явуулын AQMS-9000 станцын салхины хурд чиглэл хэмжигч YOUNG маркийн анализатор нийлүүлэх ажлыг гүйцэтгэх аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Н.Эрдэнэбилэг	Нийслэлийн Байгаль орчны ногоон хөгжлийн газрын орлогч дарга / зөвшилцсөнөөр /
---------------	--

Гишүүд:

Н.Билэгсайхан	Нийслэлийн Байгаль орчны ногоон хөгжлийн газрын мэргэжилтэн / зөвшилцсөнөөр /
---------------	---

Ц.Төмөрбаатар	Нийслэлийн Үйлдвэр, Хөдөө аж ахуйн газрын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн / зөвшилцсөнөөр /
---------------	--

Д.Батжаргал


Сонгино хайрхан дүүрэг, 12-дугаар хороо
/ зөвшилцсөнөөр /

Нарийн бичгийн дарга:

Б.Баясгалан

Нийслэлийн Агаарын чанарын албаны
мэргэжилтэн

2. Дээрх бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэх аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо / Н.Эрдэнэбилэг /-нд хяналт тавьж ажиллахыг дэд дарга Х.Галымбект үүрэг болгосугай.

ДАРГА  Ч.БАТСАЙХАН

